

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын  
2024 оны ... сарын ... -ны өдрийн  
А/... дугаар тушаалын хавсралт

## АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам” (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Ашигт малтмалын зөвшөөрлийг (цаашид “Тусгай зөвшөөрөл” гэх) олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг олон нийтийн хяналтын дор ил тод, нээлттэй, шударга өрсөлдөх, тэгш боломжоор хангах зарчмыг баримтлан зохион байгуулна.

1.3. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2.24-т “Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ” гэж заасан бодлогыг баримтлан Ашигт малтмалын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид тус тус нийцүүлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

1.4. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон энэ журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.4. Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон энэ журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.5. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалттай холбоотой энэхүү журмаар зохицуулаагүй аливаа асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.

### ХОЁР. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

2.1. Сонгон шалгаруулалтад Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан шаардлага хангасан Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээд оролцох бөгөөд хүсэлт илгээхдээ дараах журмыг баримтална:

2.1.1. оролцогч сонгон шалгаруулалтын цахим системд нэвтэрч (цаашид Цахим систем гэх), Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5-д заасан үйлчилгээний хураамжийг урилгад заасан зааврын дагуу төлснөөр тухайн сонгон шалгаруулалтын талбайн ерөнхий мэдээлэлтэй танилцах,

Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасан хүсэлт (цаашид хүсэлт гэх) бүртгэх холбоос цэсийг ашиглах эрхтэй болно;

2.1.2.оролцогч нь тухайлсан талбайн сонгон шалгаруулалтад өрсөлдөх Ашигт малтмалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5-д заасан үнийн саналын дүнг талбайн босго үнийг оролцуулан бүртгэлийн цахим системд байгаа цонхонд тоо болон үсгээр зөрүүгүй бичиж бөглөнө;

2.1.3.сонгон шалгаруулалтын талбайн босго үнэ гектар тутамд 4500 төгрөгөөр илэрхийлсэн мөнгөн дүн байхаар тооцно.

2.1.4.оролцогч нь цахим системд байрлах Сонгон шалгаруулалтын хүсэлт бүртгэх холбоос цэсийг ашиглан босго үнийг төлж, үнийн санал болон техникийн саналыг (Журмын 1, 2, 3 дугаар хавсралтуудын хамт) боловсруулан, “pdf” форматад гаргацтай, тод хөрвүүлэн, хүсэлт хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахим хэлбэрээр хүсэлтээ илгээнэ;

2.1.5.оролцогч энэ журмын 2.1.4-т заасан сонгон шалгаруулалтын материалыг илгээнээр тусгай кодоор баталгаажсан, огноо бүхий хүсэлт хүлээн авсан тодорхойлолт оролцогчдод илгээгдэж бүртгэл хүчинтэй болно;

#### ГУРАВ.СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ҮНИЙН БОЛОН ОРОЛЦОГЧИЙН ТЕХНИКИЙН САНАЛЫГ ҮНЭЛЭХ

3.1. Сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэхдээ дараах журмыг баримтална:

3.1.1. хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 70 (дал) оноог өгнө. Бусад оролцогчдын ирүүлсэн үнэ бүрийг бүртгэлийн системд бүртгүүлсний дагуу хамгийн өндөр үнэтэй харьцуулж доорх томьёогоор тооцоолно.

$$\text{Бусад оролцогчийн үнийн санал} \\ \text{Бусад оролцогчийн үнийн саналын оноо} = \frac{\text{Хамгийн өндөр үнийн санал}}{70}$$

3.1.2. Оролцогчийн буюу сонгон шалгаруулалтын үнийн саналын оноо нь 40 (дөч) оноонд хүрээгүй техникийн саналд цаашид үнэлгээ хийхгүй бөгөөд цахим хуудсанд байршуулж оролцогч байгууллагуудад мэдэгднэ.

3.1.3. Оролцогчдын үнийн саналын үнэлгээний үр дүнг цахим систем автоматаар тухайн сонгон шалгаруулалтад оролцож буй оролцогчдод мэдээлэх бөгөөд комиссын нарийн бичгийн дарга тэмдэглэл үйлдэн комиссын дарга, гишүүдэд танилцуулна.

3.2. Сонгон шалгаруулалтын оролцогчийн техникийн саналыг үнэлэхдээ дараах журмыг баримтална:

3.2.1. Комисс нь сонгон шалгаруулалтын үнийн саналын оноо нь 40 (дөч) болон түүнээс дээш оноо авсан оролцогчийн техникийн саналыг 30 (гуч) хүртэл оноогоор үнэлнэ;

3.2.2. оролцогдоос ирүүлсэн техникийн санал нь хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр эрхийн хугацаанд тодорхой үндэслэл тооцоо, судалгаанд тулгуурласан, хэрэгжих боломжтойг төлөвлөсөн эсэхийг харгалзан үнэлгээний хуудас (Журмын 4 дүгээр хавсралт)-т заасны дагуу үнэлнэ.

3.2.3. комиссын гишүүдийн баталгаажуулсан техникийн саналын оноог цахим системд байршуулна.

3.3. Унийн болон техникийн саналын оноог нэгтгэж шалгаруулахад дараах журмыг баримтална:

3.3.1. комиссын нарийн бичгийн дарга нь оролцогдоос ирүүлсэн үнийн болон техникийн саналыг журмын 3.1, 3.2-д заасны дагуу үнэлсэн үнэлгээний оноог нэгтгэж, хуралдааны тэмдэглэл үйлдэнэ;

3.3.2. сонгон шалгаруулалтад хоёр болон түүнээс дээш оролцогч нь адил үнэлгээ авсан бол хүсэлтээ цахим системд өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлт гаргана.

## ДӨРӨВ. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

4.1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмал, газрын тосны газар нь Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6, 20.7-д заасны дагуу олгоно.

4.1.1. шалгарсан оролцогч нь энэ журмын 2.1.3-т заасан үнийн саналд тусгасан мөнгөн дүнг төлөөгүй бол тус оролцогчийн босго үнийг улсын төсөвт төвлөрүүлж, буцаан олгохгүй.

4.1.2. шалгарсан оролцогч нь Ашигт малтмалын тухай хуулийн 20.5.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд нийлбэр оноогоор хоёрт орсон оролцогчид тусгай зөвшөөрлийг олгож болно;

4.1.3. журмын 4.1.2 дахь заалтыг шалгарсан оролцогчийн нийлбэр онооноос хоёрт орсон оролцогчийн нийлбэр оноо 10-аас доошгүй хувиар зөрүүтэй тохиолдолд хэрэглэнэ.

## ТАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Комиссын бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д заасны дагуу геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар сонгон шалгаруулалтын комисс(цаашид "Комисс" гэх)-ын бүрэлдэхүүнийг батална;

5.1.2.сонгон шалгаруулалтыг тасралтгүй зохион байгуулах, ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс 3 (гурав) хүртэл тооны комиссыг томилж болох бөгөөд комиссын бүрэлдэхүүний 2/3-ийг хагас жил тутамд өөрчилж болно;

5.1.3.комисс нь дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдээс бүрдсэн нийт 6 (зургаа) хүний бүрэлдэхүүнтэй байна. Нарийн бичгийн дарга нь саналын эрхгүй байна.

5.1.4.комиссын гишүүн нь геологийн судалгаа, хайгуулын төлөвлөгөө, тайланг үнэлэх мэргэжлийн чадвар, туршлагатай, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба болон салбарын төрийн бус байгууллагын төлөөлөл байна;

5.1.5.комиссын саналын эрхтэй гишүүдийн 4 ба түүнээс дээш нь журамд заасан хугацаанд үнэлгээ хийж, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.2-т шаардлага хангасан тоон гарын үсгээр баталгаажуулснаар комиссын үнэлгээ хүчин төгөлдөр болно;

5.1.6.журмын 3.1.2-т заасны дагуу 2 болон түүнээс дээш тооны сонгон шалгаруулалтын комисс томилсон тохиолдолд сонгон шалгаруулалтын үнэлгээг ээлж, дараалан гүйцэтгэнэ;

## 5.2.Комисс нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.2.1.сонгон шалгаруулалтыг урилгад заасан хугацаанд эхлүүлэх;

5.2.2.сонгон шалгаруулалт явуулах тухай холбогдох тушаал, шийдвэрийг танилцуулах, оролцогчдоос сонирхсон асуудлаар тайлбар авах;

5.2.3.ирүүлсэн бүх хүсэлт нь энэхүү журамд заасан шаардлагыг хангаагүй бол тухайн сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, дахин сонгон шалгаруулалт зарлах тухай дүгнэлт гаргах;

5.2.4.сонгон шалгаруулалтын үйл явцыг баримтжуулж, тухай бүр тэмдэглэл үйлдэх;

5.2.5.комиссын гишүүд нь Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хуульд заасан мэдээллийг задлах, нийтлэх буюу тараахгүй байх;

## 5.3.Комиссын дарга, гишүүд нь дараах эрх, үүрэгтэй:

5.3.1.Комиссын дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1.1.Комиссын хурлыг удирдаж, үйл ажиллагаатай холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр шуурхай авч нэгдсэн удирдлагаар хангах;

5.3.1.2.Комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох баримт бичигтэй тухай бүр танилцах, комиссын гишүүдэд шаардлага тавьж ажиллах;

5.3.2.Комиссын гишүүд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.2.1.Комиссын хуралд саналын эрхтэйгээр холбогдох үнэлгээ хийж оролцох;

5.3.2.2.Ашигт малтмалын тухай хуульд заасан хугацаанд багтааж үнэлгээ хийх;

5.3.2.3.Комиссын хуралд тогтмол оролцож, комиссын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах;

5.3.2.4.Комиссын хуралдаанаар хэлэлцэх оролцогчдоос ирүүлсэн хүсэлтэд мэргэжлийн санал, дүгнэлтийг гаргаж оролцох;

5.3.2.5.Комиссын дарга нь комиссын гишүүний эрх, үүргийг нэг адил хэрэгжүүлэх;

5.3.2.6.Комиссын гишүүн өөрийн биеийн эрүүл мэндийн шалтгаан болон бусад шалтгаанаар комиссын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргах.

5.3.2.7.Ашиг сонирхлоос ангид байх.

5.4.Комиссын нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байна:

5.4.1.нарийн бичгийн дарга нь үнэлгээ хийхгүй бөгөөд сонгон шалгаруулалттай холбоотойгоор хурлын тэмдэглэл хөтлөх, сонгон шалгаруулалттай холбоотой материалыг архивт хүлээлгэн өгөх;

5.4.2. сонгон шалгаруулалтын үнэлгээний нэгтгэлийг бэлтгэж комисст танилцуулах;

5.4.3.Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.4.4.Комиссын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах;

5.4.5.Хууль хяналт, шүүх болон эрх бүхий байгууллагаас Комисстий холбоотой асуудлаар маргаан шийдвэрлэх, хяналт, шалгалт хийх тохиолдолд шаардлагатай баримт, мэдээллийг тухай бүрд нь гаргаж өгөх.

5.5.Оролцогч нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.5.1.сонгон шалгаруулалтын журамтай танилцаж судалсан байх;

5.5.2.сонгон шалгаруулалтын урилгаар зарласан 1 (нэг) болон түүнээс олон талбайд хүсэлт ирүүлэх;

5.5.3.хүсэлтэд ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцна.

5.5.4.сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу гаргах.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

### 6.1. Энэ журмыг зөрчсөн этгээдэд дараах хариуцлага хүлээлгэнэ:

6.1.1. үнийн болон техникийн саналыг үнэлэх явцад комиссын дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нь энэхүү журамд заасныг зөрчиж, эрх мэдлээ урвуулан ашигласан бол Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх;

6.1.2. энэ журамд заасныг зөрчсөн нь нотлогдож, холбогдох хариуцлага хүлээхээр болсон Комиссийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг дахин комиссын бүрэлдэхүүнд оролцуулахгүй.

6.1.3. шалгарсан оролцогч нь Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.3-т заасны дагуу болсго үнийн зөрүүг төлөөгүй тохиолдолд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт уг журмаар зохион байгуулж буй сонгон шалгаруулалтад дахин оролцуулахгүй, эрхийг нь хязгаарлах этгээдийн жагсаалтад бүртгэгэнэ.

### 8.2. Маргааныг хянан шийдвэрлэхэд дараах журмыг баримтална:

8.2.1. сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалтын үнэлгээтэй холбоотой гомдлыг Ашигт малтмалын тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу гаргаж болно.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох  
сонгон шалгаруулалтын журмын 1 дүгээр хавсралт

## МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ ЗӨВШӨӨРӨЛ

Огноо

..... /аж ахуй нэгжийн нэр/ нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох Сонгон шалгаруулалтын ..... дугаар талбайд сонгон шалгаруулалтад оролцож байгаа тул сонгон шалгаруулалтын комисст улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн мэдээлэл болон татварын албаны тодорхойлолттой танилцахад зөвшөөрөл олгож байна.

Албан ёсны шуудангийн хаяг: .....

Эрх бүхий албан тушаалтны утас: .....

Цахим шуудангийн хаяг: .....

Жич: Улсын бүртгэлийн гэрчилгээ хавсаргах.

Зөвшөөрсөн:

..... /

/

Эрх бүхий албан тушаалтан

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын 2 дугаар хавсралт

## ТӨСӨЛД ОРОЛЦОХ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЖАГСААЛТЫН МАЯГТ

202 ... оны ... -р сарын ... –ны өдөр ..... аймгийн ..... сумын нутаг ..... га бүхий ..... нэртэй талбайд ус, газрын тос, уламжлалт бус газрын тосноос бусад ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл олгохоор зарласан ..... талбайн кодтой сонгон шалгаруулалтанд оролцохор ирүүлсэн төсөлд оролцох мэргэжлийн боловсон хүчний жагсаалтыг гаргаж байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох  
сонгон шалгаруулалтын журмын 3 дугаар хавсралт

### ТӨСӨЛД ХЭРЭГЛЭГДЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТЫН МАЯГТ

202 ... оны ... -р сарын ... -ны өдөр ..... аймгийн ..... сумын нутаг ..... га бүхий ..... нэртэй талбайд ус, газрын тос, уламжлалт бус газрын тосноос бусад ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл олгохоор зарласан ..... талбайн кодтой сонгон шалгаруулалтанд оролцохор ирүүлсэн төсөлд оролцох тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргаж байна.

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн нэр	марк	улсын бүртгэлийн дугаар	зориулалт	Өмчийн хэлбэр	
					Өөрийн	Гэрээт
1						
2						
3						
4						
5						

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох  
сонгон шалгаруулалтын журмын 4 дүгээр хавсралт

## **ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

..... оны ... дугаар сарын ....-ны өдөр ..... (аж ахуйн нэгжийн  
нэр)

.....  
.....  
.....  
.....  
.....

(талбайн нэр) (аймаг, нийслэл) (сум,  
дүүрэг)

<b>№</b>	<b>Шалгуур узүүлэлт</b>	<b>Үнэлгээ</b>	<b>Оноо</b>
<b>1</b>	<b>Төслийн техникийн баримт бичгийн үнэлгээ</b>		<b>2-18</b>
	<b>Талбайн геологи, хайгуулын ажлын төлөвлөлт</b> Геологи, хайгуулын ажлыг оновчтой, гүйцэд төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг бүрэн судалж, байж болох бүх төрлийн ашигт малтмалын үнэлгээ өгсөн байх, арга аргачлалд судалгааны ажил зохимжтой зөв төлөвлөгдсөн байх.	<b>0-12</b>	
1.1	Геологи хайгуулын ажил төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг гүйцэт судлаагүй, хайгуулын шатны ажлуудыг ерөнхийд нь төлөвлөсөн байх.	10-12	
	Геологи, хайгуулын ажлын төлөвлөлт хангалтгүй: Хайгуулын талбайн мэдээлэлтэй бүрэн танилцаагүй, судалгааны ажлын зорилго тодорхой бус, хайх ашигт малтмалын эрлийн ажил оновчтой бус.	6-9	
	<b>БОХ, нөхөн сэргээх ажил, зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг тооцсон төлөвлөлт, мэдээлэл</b> Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг бодитой төлөвлөсөн /бүрэн хангалттай/: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малтарт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалттай төлөвлөгдсөн байх	<b>0-6</b>	
1.2	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг алдаатай төлөвлөсөн байх /төлөвлөсөн/: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малтарт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалтгүй, дутуу төлөвлөгдсөн байх	5-6	
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлыг бодитой төлөвлөсөн /бүрэн хангалтгүй/: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малтарт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд буруу төлөвлөсөн зардал хангалтгүй байх	3-4	
2	<b>Мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар</b>		<b>0-7</b>
	<b>Мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байдал</b>	<b>4</b>	
2.1	Төслийг гүйцэтгэх өөрийн үндсэн ажилтантай буюу ИТА болон Геологчид 100 хувь хангагдсан эсэх (НДШ төлөлтийн тодорхойлолт, бусад нотолгоотой байх).	4	
	Төслийг гэрээгээр гүйцэтгүүлэх бол (ИТА болон Геологчид <99 хувь).	0-3	
	<b>Мэргэжлийн боловсон хүчиний туршлага, чадвар</b>	<b>3</b>	
2.2	Монгол Улсын Зөвлөх геологич ажилладаг	3	
	Монгол Улсын Мэргэшсэн геологич ажилладаг	2	
	3.2.3 Аль аль нь байхгүй	0-1	

<b>3</b>	<b>Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжийн мэдээллийн үнэлгээ (Гэрээ болон хавсралтаар баталгаажсан байна.)</b>	<b>0-5</b>
3.1	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн өмчийн өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бол ( <i>өрөм, геофизийккийн багажны нотлох хавсралтууд</i> )	5
	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийг түрээсэлдэг эсвэл гэрээгээр хайгуулын ажил гүйцэтгүүлэх бол ( <i>Хамтран ажиллах гэрээ</i> )	3-4
	Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх техник тоног төхөөрөмжийн мэдээлэл ирүүлээгүй болон алдаатай, ирүүлсэн бол	0-2
<b>НИЙТ ОНОО</b>		<b>30 хүртэл</b>